

Ядмаагийн Цэрэндагва<sup>✉</sup>

<sup>1</sup>Шинжлэх ухааны Академийн Археологийн хүрээлэн,  
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө,  
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

### Ховд аймгийн нутагт эртний хүн суурьшсан асуудал: чулуун зэвсгийн судалгааны тойм, дурсгалууд

**Товчлол.** Ховд аймгийн нутаг дэвсгэр дэх чулуун зэвсгийн үеийн дурсгалыг судлах ажил 1950-аад оноос эхэлжээ. Тус аймгийн чулуун зэвсгийн судалгаанд Монгол, Зөвлөлтийн хамтарсан чулуун зэвсгийн судалгааны анги, МЗТСХЭ голлох үүрэг гүйцэтгэсэн юм. Одоогийн байдлаар тус аймгийн нутгаас палеолит, мезолит, неолитын үед холбогдох 102 дурсгалт газар илэрч, судалгааны эргэлтэд ороод байна. Дээрх дурсгалт газар, олдвор хэрэглэгдэхүүнээс харахад доод палеолитын үеэс эхлэн Монгол Алтайн нурууны томоохон гол мөрний сав, уул хоорондын ан амьтан элбэг үржил шимт хөндий бараадан эртний хүмүүс амьдарч байсан нь батлагддаг.

**Түлхүүр үг.** *Ховд аймаг, чулуун зэвсэг, доод палеолит, дунд палеолит, дээд палеолит, неолит, чулуун зэвсгийн үйлдвэрлэл.*

Tserendagva Yadmaa<sup>✉</sup>

<sup>1</sup>Institute of Archaeology,  
Mongolian Academy of Sciences Building-1,  
Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

### The problem of early human in the territory of the Khovd aimag: A review of Stone Age research and main sites

**Abstract.** The study of Stone Age Khovd Aimag, began in the 1950s. Joint Mongolian-Soviet Union archaeological team for studying Stone Age and joint Mongolian-Soviet Union historical and cultural expedition played a major role in the study of Stone Age in the territory Khovd Aimag. At present, 102 sites related to the Paleolithic, Mesolithic, Neolithic periods have been discovered and studied. These sites and stone tools from them show that starting from the Lower Paleolithic, ancient people began to settle in the intermountain plains, where are many animals for hunting, and in the basin of large rivers of the Mongolian Altay.

**Keywords.** *Khovd aimag, Stone tools, Lower Paleolithic, Middle Paleolithic, Upper Paleolithic, Neolithic, Stone tools industry.*


#### Чулуун зэвсгийн судалгааны тойм

Газарзүйч О.Намнандорж 1952 онд Ховд аймгийн Үенч сумын Байтаг Богдын Дамжигийн ус, Тахийн усны Өвдөг Түнх зэрэг газруудаас чулуун зэвсгийн хоёр дурсгалт газар илрүүлэн олжээ [Доржсүрэн, 1957: 9]. Дамжигийн уснаас 100 чулуун зэвсэг түүвэрлэсний дотор залтас 86 байсан байна. Үлдсэн эдлэлүүдээс долоо нь хуучин чулуун зэвсгийн дунд, бусад нь неолитын үед холбогдох багаж зэвсэг байв. Хуучин чулуун зэвсгийн дунд үед хамаарах багаж зэвсгийг хусуур маягийн зэвсэг (1 ш), хянгар (2 ш), зурваслуур (1 ш) хэмээн Ц.Доржсүрэн төрөлжүүлэн ангилжээ. Өвдөг түнхээс нийт 50 чулуун зэвсэг цуглуулсны дотор залтас 48, үзүүр мäs 2 байжээ.

1966 онд Н.Сэр-Оджав, Д.Дорж, А.П.Окладников, А.П.Деревянка, В.Е.Ларичев, В.В.Волков, И.В.Жалковский, жолооч С.А.Алексеев нарын бүрэлдэхүүнтэй Монгол, Зөвлөлтийн хамтарсан чулуун зэвсгийн судалгааны анги Ховд хотын орчим Цэнгэлдэх хүрээлэнгийн баруун тал Буянт голын намхавтар дэнжээс нэг, Буянт голын гүүрний орчим дахь дэнжээс нэг, Рашааны голын эргээс нэг, Зумьяагийн голын хөндийгөөс гурван бууц, буудал, Ховд аймгийн Манхан сумын нутаг Хойт Цэнхэрийн голын савын Бор өвдөгийн бууц, Манхан сумын төвийн орчмоос хэд хэдэн палеолитын үеийн бууц суурин, Мөст сумын төв орчим, Цэцэг сумын нутаг Бамбагар уулын орчмоос палеолитын

дурсгалт газар, Ховд аймгийн төвөөс Өлгий орох замын 15 км-т Шар нуурын талын Хаалгач уулын (Я.Ц) урд хормойд орших боржин чулуун цохионы дэргэдээс неолитын арвин баялаг хэрэглэгдэхүүн бүхий хоёр суурин тус тус илрүүлэн олсон юм [Окладников, Ларичев, 1967:89]. Рашаантын голын эрэг дэнжээс олон тооны хайрган зэвсэг баргил залтаснууд олдсон бол Зумьяагийн голын хөндийн суурингуудаас чоппер, чоппинг, баргил хянгар зэвсэг, хайрган үлдцүүд, леваллуагийн гурвалжин, дөрвөлжин үлдцүүд, цохилтын том товгор бүхий том залтас олон тоогоор илэрсэн байна. Хаалгач уулын сууринаас олон тооны бичил үлдэц, бичил залтас, ялтаснууд цуглуулжээ. 1966 онд илэрч олдсон эдгээр эд өлгийн зарим буюу Мөст, Цэцэг, Манхан сумын нутгаас олдсон хэсгийг 1986 онд боловсруулан, судалгааны эргэлтэд оруулсан [Деревянко нар, 1986а; Деревянко ба бусад, 1986б, 1986в] бөгөөд Ховд хотын орчим, Рашааны гол, Зумьяагийн голын хөндийгөөс олдсон дурсгалууд судалгааны эргэлтэд бүрэн орж хараахан амжаагүй өнөөг хүрснийг энэ дашрамд тэмдэглэх нь зүйтэй болов уу.

1979 онд МЗТСХЭ-ийн Д.Цэвээндорж, А.П.Окладников, Ю.С.Худяков, И.В.Асеев, А.К.Конопацкий нарын судлаачдын бүрэлдэхүүнтэй чулуун зэвсэг судлах анги Ховд аймгийн Мянгад сумын нутаг Чандмань хар үзүүр, Манхан сумын Хар үзүүрийн харалдаа Цэнхэрийн голын баруун дэнж, Мөст сумын Улаан толгой, Бооржийн гол, Боом, Цэцэг сумын Уушгийн баруун хоолойн өвөлжөө зэрэг газруудаас палеолитын чулуун багаж зэвсгүүд олж судалсан байна [Цэвээндорж, 1980: 1-3]. Тэдгээрээс Чандмань хар үзүүр, Цэнхэрийн голын эдлэлүүдийг мустьен үед, бусдыг дээд палеолитод холбогдуулан үзжээ. Тухайн тайланд чулуун зэвсгийн дурсгалт газруудыг тодорхойлон өгүүлснээс гадна чухам хэдэн тооны дурсгалт газар Цэнхэрийн голын саваас олдсоныг дурдаагүй хэдий ч Манхан сумын Цэнхэрийн голын чулуун зэвсгийн эхний дөрвөн суурины байршлыг тэмдэглэсэн байр зүйн зураг хавсаргасан нь тухайн дурсгалуудын



Зураг 1. 1979 онд МЗТСХЭ-ийн судлаачид Манхан сумын төвийн ойролцоох чулуун зэвсгийн дурсгалууд, археологийн бусад дурсгалыг тэмдэглэсэн газрын зураг (Цэвээндорж, 1980)

байршлыг яв цав тогтооход үнэлж баршгүй ач холбогдолтой юм (Зураг 1). Хожим 1986 онд хэвлүүлсэн бүтээлдээ А.П.Деревянко нар Манхан сумын ойролцоогоос олдсон 14 дурсгалын чулуун зэвсгийг тодорхойлон нийтэлсэн билээ [Деревянко ба бусад, 1986б, 1986в].

1983 онд МЗТСХЭ-ийн Д.Дорж, А.П.Деревянко, В.П.Алексеев, И.В.Асеев, В.Е.Ларичев, В.Т.Петрин нарын судлаачдын бүрэлдэхүүнтэй чулуун зэвсгийн дурсгал судлах анги Ховд аймгийн Манхан сумын нутгаар голлон хайгуул хийж Хойд Цэнхэр, Дунд Цэнхэрийн голын бэлчир, Их Цахир, Хойд Цэнхэрийн агуйн ойролцоо голын эрэг дэнжээс нийтдээ 14 бууц суурин илрүүлэн, 425 чулуун зэвсгийн олдвор цуглуулсны дотор доод, дунд палеолитын үед холбогдох Хойд Цэнхэрийн гол-2 (Ишгэн толгойн орчим Я.Ц.) гэсэн томоохон дархны газар багтана [Деревянко нар, 1984: 14-16].

1984 онд МЗТСХЭ-ийн А.П.Деревянко, Д.Наваан, А.П.Алексеев, Р.С.Васильевский, В.Е.Ларичев, В.Т.Петрин, Х.Лхагвасүрэн нарын

эрдэмтдийн бүрэлдэхүүнтэй чулуун зэвсгийн дурсгал судлах анги Булган сумын нутаг Булган голын хөндий, Ярант, Үенч сумын нутаг Үенч гол, Алтай сумын нутаг Бодончийн гол, Барлаг голын сав, Алтай сумын төвийн орчим, Манхан сумын Хойд Цэнхэрийн голын сав, Мөст сумын Уртын сайрын гол, Халзан хошуу, Хүрэн толгой, Ямаатын уулын зүүн хойд бэл зэрэг газраас палеолитын, Ховд аймгийн Булган сумын Булган голын эрэг (Булган-1, 5, 6), Үенч сумын Хөв (Үенч-8, 9), Бага хар толгой (Үенч-10), Алтай сумын Бодончийн голын зүүн эрэг Хайстын үзүүрийн орчим (Алтай-3, 4), Барлаг гол (Барлаг гол-6) зэрэг газруудаас мезолит, неолитын чулуун зэвсгийн дурсгалт газрууд илрүүлэн олжээ [Деревянко нар 1985:49-55, Деревянко, Петрин, 1987, Петрин, 1987, Петрин, 1991].

1995 онд Д.Эрдэнэбаатар, З.Батсайхан, Ж.Жабар, П.Х.Жискар, Ч.Сервел нарын бүрэлдэхүүнтэй Монгол-Францын хамтарсан судалгааны баг Ховд аймгийн Манхан сумын нутаг Хойд Цэнхэрийн голын хөндийн Хөх өтөг, Тахилтын хотгор, Зах булаг, Цахирын хөдөө, Цахирын үзүүр зэрэг газруудаас 760 орчим чулуун зэвсгийн олдвор цуглуулжээ [Jabert нар 1997: 419-447].


2001 онд Ц.Баасандорж, Н.И.Дроздов нарын удирдсан Ховдын Их Сургууль, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын археологи угсаатны зүйн хүрээлэнгийн Красноярскийн археологи, эртний газарзүйн лаборатори, Красноярскийн Багшийн Их Сургуулийн хамтарсан археологийн хээрийн шинжилгээний экспедици Ховд аймгийн Манхан сумын нутаг Төгрөг голын сав, Хойд Цэнхэрийн голын хөндийн Хар үзүүр, Хар толгой, Балган толгой зэрэг газраас палеолитын үеийн долоон бууц, буудал илрүүлэн олжээ [Дроздов нар, 2001: 66-71; Дроздов нар, 2003: 155-156; Дроздов нар, 2002: 198-233].

2008 онд Улаанбаатарын Их сургууль, Ховдын Их сургууль, Алтайн Их сургуулийн хамтарсан Буянтын археологийн экспедици Буянт голын зүүн этгээдэд орших Бугатын үзүүрээс гадаргуугийн элэгдийн

байдлаараа таван бүлэгт хуваагдах 105 чулуун зэвсгийн зүйл илрүүлэн, түүвэрлэжээ [Тишкин нар, 2008а: 68-69; Тишкин нар, 2008б: 63-64; Кунгуров, Тишкин, 2008: 73-84].

2013 онд Улаанбаатарын Их сургууль, Ховдын Их сургууль, Алтайн их сургуулийн хамтарсан Буянтын археологийн экспедици Ховд аймгийн Ховд сумын нутаг Баруун салаагаас чулуун зэвсгийн 3 бууц илрүүлэн олжээ [Семибратов, Тишкин, 2016: 94-108].

2016 онд ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан А.Энхтөр, С.Далантай нар Эрдэнэбүрэн сумын Хонгио, Хавцалын голоос палеолитын үеийн хоёр дурсгалт газар илрүүлэн олжээ [Цэрэндагва нар, 2016]. Эхний дурсгалт газраас 209, хоёрдахь дурсгалт газраас 303 тооны чулуун зэвсэг түүвэрлэсэн байна.



Зураг 2. Манхан-4 дурсгалт газар болон олдворууд. 1. Манхан-4 дурсгалт газрын харагдах байдал. 2, 4, 5-Үлдэц, 3-сегментэн цуулдас (Деревянко нар, 1990)



### Чулуун зэвсгийн дурсгалт газрууд

Ховд аймгийн нутаг дэвсгэрээс чулуун зэвсгийн бүхий л үед холбогдох төрөл бүрийн олдвор хэрэглэгдэхүүн бүхий дурсгалт газрууд олджээ. Дурсгал бүр газар зүйн байрлал, олдворын тоо хэмжээний хувьд харилцан адилгүй.

#### Доод палеолит

Өнөөдрийн байдлаар Ховд аймгийн нутаг дэвсгэрээс доод палеолитын үед холбогдох 8 дурсгалт газар илрээд байна. Дээрх сууринуудаас нийтдээ 513 тооны чулуун зэвсгийн олдвор цуглуулсан. Эдгээр дурсгалын нэгийг (Манхан-4) 1979 онд, бусдыг 1983-1984 онд МЗТСХЭ-ийн чулуун зэвсгийн судалгааны анги илрүүлэн олсон юм [Деревянко нар, 1990].

**Манхан-4.** Ховд аймгийн Манхан сумын төвийн орчмоос 1966, 1979 онуудад А.П.Окладниковоор удирдуулсан шинжилгээний анги 14 дурсгалт газар, 1983, 1984 онуудад МЗТСХЭ-ийн А.П.Деревянко удирдагчтай шинжилгээний анги 16 дурсгалт газрыг тус тус илрүүлэн олж, түүвэрлэлт хийжээ. Эдгээр газруудаас Манханы 4-р дурсгалт газар палеолитын доод шатанд хамаарна. Энэхүү газар нь Баянтүмбэ уулын хошуунаас хойно 500 м орчим зайд оршино (Зураг 2, 1). Чулуун зэвсгийн олдворууд Төгрөгийн голын дэнж дагуу тархсан байдаг. Энэ дурсгалт газрыг 1979 онд анх олж судалсан байна.

Энэ дурсгалт газраас бор саарал өнгийн цахиурлаг чулуугаар хийсэн гадаргуу нь ихээхэн элэгдэж, мөлийсөн хорин долоон эдлэл цуглуулснаас бэлдэц, үлдэц харьцангуй олон тоотой.

Бэлдцүүдийн хувьд чулууны гол тэнхлэгийн жажуугаас хөндлөн чигтэй цохилт хийж байсан нь тод мэдэгдэх ба ганц эдлэлийг гол тэнхлэгийн дагуу хэд хэд хагачиж цуулсан байдаг. Хөндлөн цуулах энэ цуулалтын зарчим доод палеолитын чулуун зэвсэг цуулалтын үндсэн аргуудын нэг юм.

Манханы үлдцүүд бүгд хайрган, элэгдэл өгөршлөөс шалтгаалан цуулалтын зарчмыг тодорхойлоход нэлээд хүндрэлтэй байсан ч төрөл зүйлийн хувьд олон талбайт, цохилтын хоёр талбайт, цуулалтын нэг гадаргуут, жажуугийн (Зураг 2, 4), зэрэгцээ болон хөндлөн цуулалтын зарчимт (Зураг 2, 5), леваллуагийн хэв шинжит гэж ангилагдана. Түүнчлэн гурван үлдцээс цохилтын талбай, гадаргууг урьдчилан бэлтгэлгүйгээр цуулалт хийсэн нь мэдэгддэг (Зураг 2,2). Цохилтын талбайг урьдчилан бэлтгэлгүй ийнхүү цуулалт хийсний үр дүнд нь сегмент хэлбэрийн цуулдас гардаг. Нэг үлдцийг хянгар зэвсэг болгон хувиргасан нь сонирхол татна.

Анхдагч цуулдасны хувьд бүгд баргил, том хэмжээтэй ба зах ирмэгээр хожуу гарсан

ир ажиглагдана. Залтаснуудын гадар дээгүүр өмнөх цуулалтын олон тооны замбараагүй ором хадгалагдан үлдсэн байх бөгөөд голчлон хөндлөн цуулалттай үлдцээс цуулсан нь мэдэгдэнэ. Сегмент хэлбэрийн цуулдас хэд хэд байна (Зураг 2, 1).

Манхан-4 дурсгалт газар болон түүнтэй адил төстэй Манханы бүлэг дурсгалын холбогдох он цагийг судлаачид 650-520 мянган жилийн өмнөх (MIS 13-16) үед холбогдуулан үзсэн байдаг [Деревянко, 2017: 236].

**Хойд Цэнхэрийн гол-2.** Ховд аймгийн Манхан сумын төвөөс зүүн хойш 4 орчим км-т Хойд Цэнхэрийн голын зүүн эрэгт, Хойд Цэнхэрийн гол Дунд Цэнхэрийн голын цутгалаас хойд зүгт 800 м зайд Ишгэн толгойн бэлд байрлана. Анх МЗТСХЭ-ийн чулуун зэвсгийн судалгааны анги 1983 онд илрүүлэн олсон. Ишгэн толгойн энгэр бэлийн 100 x 200 м талбайгаас олж цуглуулсан чулуун зэвсгийн (158 ш) дотор, гадаргуу нь маш ихээр элэгдэж, өгөршсөн 22 чулуун эдлэл доод палеолитын үед холбогддог.


Доод палеолитод холбогдох чулуун зэвсгүүдийн гадаргуу дээрх цуулалтын ором, ирмэг, хянга цамцаал, ир гаргасан байдал зэрэг нь мөлийж ихэд элэгдсэн байдаг.

Үлдцийн хувьд таргил, цохилтын хоёр талбайт, цуулалтын хоёр гадаргуут, цохилтын нэг талбайт, цуулалтын нэг гадаргуутай гэж төрөлжинө.

Хойд Цэнхэрийн голын энэ суурингийн залтас, ялтас, цуулдаснуудын ирмэг элэгдсэн нь багаж зэвсгийн зүйлийг ялган танихад хүндрэл учруулдгийг дурдах нь зүйтэй.

Он цагийн хувьд Манхан-4-тэй нэг цаг үед холбогдоно [Деревянко, 2017: 236].

**Халзан хошуу (Мөст-3).** Ховд аймгийн Мөст сумын төвөөс чанх хойшоо ойролцоогоор 7 км зайтай Уртын сайрын гол, Бооржийн голын бэлчирээс холгүйхэн Халзан хошууны баруун бэлд байрлана. Эндээс нийт 5 ширхэг элэгдэж өгөршсөн чулуун зэвсэг олдсон. Бэлдцийг том хэмжээтэй, тэгш өнцөгт хэлбэрийн чулуугаар үйлдсэн. Чулууны нэг талд цохилтын талбай гарган, түүнээс туршилтын хэд хэдэн өргөн цуулалт хийжээ. Ар тал нь тэгшхэн, хайрган бүрхүүлээрээ байна. Ирлэгч нэг олдсон ба гонзгой, хавтгайдуу хайргаар хийсэн. Нэг үзүүр ихээхэн хортонтсон байдалтай байгаа нь удаан хугацаагаар ашиглаж байсныг илтгэнэ. Чоппер зэвсгийн урт нарийн чулууны өргөн талын үзүүрийг хагалан нэлэнхүйд нь шаталсан маягаар хагалж цуулжээ. Гурван талстат ялтсыг хатуу цохиурын аргаар цуулан авсан нь түүний дотор талд үлдэж хоцорсон том хэмжээний цохилтын товгороор мэдэгдэж байна. Жажуу ирмэгийн энд тэнд дотор гадна талаас нь хэсэгхэн ир гаргасан байдалтай харагдана.



Зураг 3. 1. Чулуун зэвсгийн дурсгалт газрууд олдсон Үенч голын баруун дэнж, 2-Дэвүүр хэлбэрт цуулалтат үлдэц, 3-хянгар, 4, 5, 6-үлдэц, 7-залтас, 8-бэлдэц



Зураг 4. Үенч-4 дурсгалт газрын чулуун зэвсгүүд.

Анхдагч цуулдасны хоёр урт хажуу ирмэгийн нэг нь хонхор, нөгөө нь гүдгэр дугуй хэлбэртэй.

**Үенч-1.** Ховд аймгийн Үенч сумын төвийн орчим Үенчийн голын баруун эргийн тэгш дэнжийн голруу түрэн орсон хамраас энэхүү суурин олдсон байна (Зураг 3, 1). Үенчийн голын дэнж энэ хэсэгтээ 90 м орчим өндөртэй. Цаг хугацааны хувьд энэ дэнж нь эоплейстоцены үед хамаарна. 1984 онд МЗТСХЭ-ийн чулуун зэвсгийн судалгааны ангийн судлаач В.Т.Петрин анх илрүүлэн олжээ.

Чулуун зэвсгийн дурсгал тархсан талбай 150 х 100 м хэмжээтэй байжээ. Энэ талбайгаас нийт 450 чулуун зэвсгийн зүйл олдсоноос гадаргуу нь ихээр элэгдэж өгөршсөн 426 олдворыг доод палеолитын үед холбогдуулан үздэг.

Чулуун зэвсгүүдийг цагаан саарал өнгийн, нарийн ширхэгтэй, цахиуржсан элсэн чулуугаар голлон хийжээ.

Чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн анхдагч цуулалтын хэсэгт бэлдэц (16 ш), үлдэц (51 ш), үлдэц хэлбэрийн хагархай (8 ш) багтдаг.

Бэлдцүүдийн хувьд хайрган бэлдэц голлох ба чоппинг зэвсэгтэй төстэй, нарийн үзүүрийг тайрсан бэлдцүүд бас байна. Хайрган бэлдцүүд голчлон хөндлөн цуулалтын зарчмаар бэлтгэгдсэн, цуулалтын гадаргуу нь хагас дугуй хэлбэртэй (Зураг 3, 8). Чоппинг зэвсэгтэй төстэй таван бэлдцийн хоёр талын гадаргууг бараг бүхэлд нь ирмэг захаас нь хагалж цуулжээ.

Үлдцүүд радиаль цуулалт, леваллуагийн цуулалт (Зураг 3, 6), дэвүүр хэлбэрийн цуулалт (Зураг 3, 2, 5), зэрэгцээ цуулалтын аргаар тус тус бэлтгэгджээ. Хосолмол цуулалтын зарчимт

(Зураг 3, 4), зэрэгцээдүү цуулалттай үлдэц ч тааралдана. Мөн дугариг хэлбэртэй олон талбайт үлдэц цөөн тоотой байна.

Багаж зэвсгийн хувьд ирлэсэн леваллуагийн үзүүр мэс, хянгар, хутга, холтослуур, шүдлэг хүнхэр иртэй зэвсэг, өвөрмөц зэвсгүүд тааралдана. Тэдгээрээс хянгар зэвсэг хамгийн олон тоотой буюу нийт хорин дөрвөн тоотой олдсон. Ир гаргасан байдлаараа дотроо дан иртэй тэгш хянгар, дан иртэй гүдгэр хянгар, хөндлөн иртэй тэгш хянгар, хөндлөн иртэй гүдгэр хянгар, дотор талдаа иртэй, давхар иртэй хянгар, дан иртэй хотгор хянгар гэж төрөлжинө. Ирийг нэг болон хоёр эгнээ, босоо байдлаар холтчин гаргасан байх ажээ.

Өвөрмөц хэлбэрийн зэвсгүүдийн нэг нь хүнхэр ховил, хянгарын ирлэлтийг хослуулсан леваллуагийн цуулдас байна. Гурван зэвсгийн зүүн хажууг хянгар зэвсэг мэт ирлээд, үзүүр болон эсрэг талуудад хамар, нарийн ир, хүнхэр ховил зэргийг гаргасан нь өвөрмөц хэлбэртэй болгожээ.

Цуулдасны үйлдвэрлэлийг авч үзэхэд олон тооны анхдагч, хоёрдогч залтас (Зураг 3, 7, 5), цуулдас, леваллуагийн залтас, ялтас, сегмент хэлбэрийн цуулдас (Зураг 3, 3) багтана.

Үенчийн 1-р дурсгалт газар бол газар зүйн маш таатай орчинд байрлаж байсан суурин-дархны газар юм. Чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн хувьд нэгдмэл. Уг дурсгалыг судалсан судлаачид он цагийн хувьд 650-560 мянган жилийн өмнөх үед (MIS 14-16) холбогдуулан авч үзэх санал гаргасан байдаг [Деревянко, 2017: 212].

**Үенч-4.** Ховд аймгийн Үенч сумын төвөөс хойш 4 км зайтай орших Үенчийн голын баруун



талын нэгэн том сайрын хажуугийн хошуурсан дэнжийн орой дээр байрлана.

Эндээс арван гурван тооны чулуун зэвсгийн дурсгал олдсны элэгдэл өгөршил ихтэй арван нэгэн чулуун зэвсгийг доод палеолитын үед холбогдуулан үздэг.

Чулуун зэвсгийн үйлдвэрлэлд олон янзын арга ажиллагааг хэрэглэж байсан нь үлдцүүдээс тод харагдана. Нийт 5 үлдэц байгаа бөгөөд тэдгээрээс харахад хоёр нь леваллуагийн арга барилаар, нэг нь цуулалтын нэг гадаргуут, цохилтын нэг талбайт (Зураг 4, 1), нэг нь пик зэвсэгтэй төстэй, хайрган (Зураг 4, 2), нэг нь гурвалжин хэлбэртэй, том ялтас цуулан авахаар бэлтгэн зассан (Зураг 4, 3) байна.

Багаж зэвсгийн төрөлд тэгш иртэй хянгар, иртэй ялтас багтана. Хянгарыг том томоор холтлон ирлэсэн бол ялтсыг жигд холтлон ирлэсэн байна.

**Үенч-6.** Ховд аймгийн Үенч сумын төвөөс баруун хойш 5 км зайд Үенчийн голын баруун эргийн эртний дэнжид байрлана. Ойролцоогоор 50 x 200 м хэмжээний талбайг хамарсан хайгуулын дүнд 12 тооны саарал өнгийн элсэн чулуугаар хийсэн чулуун зэвсэг олдсоны гадаргуу бүхэлдээ цөлийн гандаас буюу өнгөр гялтга эрчимтэй тогтсон, арсгар барсгар байдалтай болсон байжээ.

Таван үлдцийн гурвын гадаргуу нь ихээхэн элэгдэлтэй. Төрөл зүйн хувьд радиаль цуулалтын зарчимт, дэвүүр маягийн цуулалтын зарчмаар бэлдсэн цохилтын нэг талбайт, цуулалтын нэг гадаргуут хайрган, дөрвөн талбайт, хоёр цуулалтын гадаргуутай гэж ангилагдана. Өөр нэг үлдцийг хайрганы хагархайгаар хийсэн ба хоёр цуулдас авсан оромтой.

Үлдэц хэлбэрийн цуулдасны нэг ирмэгийг зассан байна. Мөртэй ялтасны дээд хэсгийн хугархай ирлэж зассан шинжгүй. Сегмент хэлбэрийн цуулдас хэмжээний хувьд жижгэвтэр, хайрган чулуунаас хөндлөн байдлаар цохиж цуулсан нь мэдэгдэнэ.

Үенч-4, Үенч-6 дурсгалт газраас цөөн тооны эдлэл цуглуулсан хэдий ч доод палеолитын үеийн үйлдвэрлэлийн аргыг тод томруун харуулдаг. Оросын нэрт чулуун зэвсэг судлаач А.П.Деревянко эдгээр дурсгалын он цагийг Үенч-1-ээс эрт үед холбогдохыг цохон тэмдэглэжээ [Деревянко, 2017: 212]. Хэрэв Үенч-1-ийг MIS 14-16 буюу ойролцоогоор 650-550 мянган жилийн өмнөх үед холбогдуулан авч үзэх саналыг харгалзан үзвэл дээрх дурсгалт газрын чулуун зэвсгийн үйлдвэрлэл 700 мянган жилээс ч өмнөх үед холбогдох магадлалтай юм.

**Барлаг гол-1.** Ховд аймгийн Алтай сумын нутагт сумын төвөөс зүүн тийш 60 орчим км зайд Барлаг голын зүүн эрэгт орших ногоовтор өнгийн фельцитэн хадан тогтоцтой уулын баруун энгэрийн дэвсгэг дээр байрлана. Чулуун зэвсгийн

дурсгалууд дэвсгийн 40 x 50 м хэмжээний талбайд тархсан байдалтай олджээ. Эндээс нийтдээ 147 чулуун зэвсгийн олдвор олж түүвэрлэсний ихээхэн хэмжээгээр элэгдэж өгөршсөн 7 эдлэлийг доод палеолитын үед холбогдуулан үздэг. Доод палеолитын чулуун зэвсгийн цуглуулгыг үлдэц (3 ш), леваллуагийн залтас (2 ш), баргил залтас (2 ш) бүрдүүлнэ. Үлдэц, залтсыг улаан өнгийн цахиурлаг чулуугаар хийсэн ажээ.

Гурван үлдцийн хоёр нь яст мэлхий хэлбэрийн төрхтэй, леваллуагийн цуулалтын зарчмаар бэлтгэсэн. Эхнийх нь том хэмжээтэй, нөгөө нь уртавтар. Том үлдцээс ганц өргөн залтас авсан бол уртавтар үлдцийн цуулалтын гадаргууг хажуу захаас нь төв рүү чиглэсэн цуулалтаар бэлтгэсэн. Ар тал нь тэгшхэн, маш их элэгдсэн тул цуулалтыг тодорхойлох боломжгүй болжээ. Гурав дахь үлдэц том хэмжээтэй, радиаль төрөлд хамаарна. Түүнээс өргөн залтаснууд авчээ.

Леваллуагийн залтаснуудын хувьд гадаргуу нь ихээр элэгдсэн байдалтай. Баргил залтасны хувьд хэмжээний хувьд харьцангуй том. Цохилтын талбайн үлдэгдэл нь тэгш, гөлгөр. Том цохилтын товгортой.

**Барлаг гол-5.** Барлаг голын бусад дурсгалууд байрлах уулаас хойш 5-6 км зайтай өргөн хөндийн дунд орших дэвсгэг газарт байрлана. Эндээс маш их элэгдэж өгөршсөн хоёр ялтас, нэг сегментэн цуулдас олджээ. Нэг ялтасны үзүүр хэсэг хугарсан ба он удаан жил газрын гадарга дээр хэвтэж нарны нөлөөгөөр гадаргуу нь гялалзсан өнгөр тогтсон байна. Дараагийн ялтас нь үлдцийг дахин засахад гарсан хоёрдогч ялтас юм. Сегментэн цуулдасны гадаргууг өгөршил ихээхэн өөрчилсөн юм.

Барлаг голын доод палеолитын хоёр дурсгалт газар он цагийн хувьд 470-370 мянган жилийн өмнөх үед холбогдох магадлалтай байна [Деревянко, 2015: 212].

Ховд аймгийн нутагт судлагдсан доод палеолитын үеийн чулуун зэвсгийн бууц, суурингуудын үйлдвэрлэлийг тандан үзэхэд анхдагч цуулалт нь олон төрлийн үлдцээр илэрхийдэгдэнэ. Манхан-4, Хойд Цэнхэрийн гол-2 суурингийн хувьд хайрган үлдэц, бэлдэц үндсэн төрлийг бүрдүүлнэ. Тэдгээр хайрган үлдцүүдийн гадаргуугийн цуулалтын ормоос харахад замбараагүй цуулалт зонхилж байна. Бусад үлдцүүдийн хувьд леваллуагийн, цацарган цуулалтаг, зэрэгцээ цуулалтын зарчимт гэж хуваагдана. Доод палеолитод холбогдох чулуун зэвсгүүдийн гадаргуу маш их элэгдэж мөлийсөн байгаа тул багаж зэвсгийг ялган тодорхойлох боломжгүй байжээ. Цуулдаснуудын хувьд залтас голлох ба өргөн ялтас, ялтсан цуулдас, сегментэн цуулдас тодорхой тоотой байна.

Мөст-3, Барлаг голын хоёр суурингаас чулуун


зэвсэг цөөн тоотой олдсон хэдий ч төрөл зүйл бүтцийн хувьд сонирхолтой. Дээрх газруудаас доод палеолитын үйлдвэрлэлийн шинжийг тод томруунаар илэрхийлэх, хугадас зэвсэг, леваллуагийн үлдэц, том баргил залтас, цуулдаснууд илэрч олдсон юм.

Үенч-1 суурнгийн хувьд Ховд аймгаас төдийгүй Монгол улсын нутаг дэвсгэрээс урьд өмнө илэрч байгаагүй нэгдмэл, өвөрмөц чулуун зэвсгийн үйлдвэрлэл байгаа нь тогтоогдсон. Чулуун зэвсгүүд дотор бэлдэц, үлдэц, багаж зэвсгийн эзлэх хувь маш өндөр.

Ховд аймгийн нутаг дэвсгэрээс илэрч олдсон доод палеолитын үеийн дурсгалууд бүгд газрын хөрсөн дээрээс олдсон ил бууц сууринууд юм. Ийм дурсгалуудын он цагийг яв цав тогтоох асуудал хүндрэлтэй байдаг хэдий ч чулуун зэвсгийн гадаргуугийн элэгдлийн байдал, дурсгалт газрын байрлал, он цаг нь тогтоогдсон соёлт давхарга бүхий дурсгалуудтай үйлдвэрлэлийн арга ажиллагааг харьцуулах замаар он цагийн тогтоодог. Энэ ч үүднээс Ховд аймгийн доод палеолитын дурсгалуудын он цагийг баримжаалан тогтоосон байна. Судлаачдын дүгнэн тодорхойлсноос үзэхэд Ховд аймгийн нутгаас олдсон хамгийн эртний дурсгалт газар бол Үенч-4, Үенч-6 юм. Судлаачид 700 гаруй мянган жилийн өмнөх үед холбогдуулан үзжээ. Удаад нь 650-520 мянган жилийн өмнөх үед холбогдох Үенч-1, Манханы дурсгалууд орно. Барлаг голын дурсгалт газруудын хувьд 470-370 мянган жилийн өмнөх үед холбогдохоор байна. Бусад сууринуудын хувьд доод палеолитын төгсгөлийн шатанд хамаарна.

#### Дунд палеолит

Ховд аймгийн нутаг дэвсгэр дээр амьдарч



Зураг 5. Ховд аймгийн нутгаас олдсон дунд палеолитын чулуун зэвсгүүд  
1, 4, 6, 8, 9, 10, 11, 13, 14, 17 – леваллуагийн үлдэц; 2, 3, 12, 16 – бэлдэц; 5 – хөндлөн үлдэц; 7 – олон талбайт үлдэц; 15 – радиаль үлдэц (1, 10, 12 – Барлаг-2; 2 – Хойд Цэнхэрийн гол-2; 3, 4, 5 – Манхан-1; 6 – Манхан-11; 7, 16 – Манхан-6; 8, 9, 11, 13, 15, 17 – Барлаг-1; 14 – Манхан-7) (Деревянка нар 1990).

байсан эртний хүмүүс 135 мянган жилийн тэртээд дунд палеолитод шилжин оржээ. Чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн хөгжил, нэн эртний хүний хувьсал өөрчлөлттэй энэ үе холбогддог. Энэ үеийн түүхийг *Homo neanderthalensis* буюу Неандертал хүнтэй холбон авч үздэг. Доод палеолитын үед эхлэл нь тавигдсан чулуун зэвсэг хийх өвөрмөц арга болох леваллуагийн арга энэ үед бүрэн боловсорч хөгжиж чадсан юм. Хянгар зэвсгийн ир гаргалт



нэлээд өвөрмөц болж ирсний дээр шүдлэг ир гаргах арга барил бүрэлдэн тогтсон нь энэ үеийн чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн нэг онцлог юм. Доод палеолитын гилбэр (гар сүх) зэвсгийн хэрэглээ багасаж, гилбэр зэвсгийг нимгэн залтас цуулдсаар хийх болсны дээр хэмжээ нь багасаж, холын тусгалт охор жад ихээр хэрэглэх болсонтой уялдан жинхэнэ сонгодог гилбэр зэвсэг хийх болсон байна. Энэхүү жадны гилбэрийн үүргийг леваллуагийн үзүүр мэс давхар гүйцэтгэж байжээ. Дунд палеолитын чулуун зэвсэг үйлдвэрлэлийн энэ өвөрмөц онцлогууд манай орны, тэр дундаа Ховд аймгаас олдсон бууц суурингуудын чулуун зэвсгийн хэрэглэгдэхүүнд тод хадгалагдан үлдсэн байдаг юм.

Ховд аймгийн нутагт дунд палеолитын үед холбогдох 29 дурсгалт газар байгаагаас Манхан сумын төвийн орчмоос 9, Хойд Цэнхэрийн голын сав дагуугаас 9, Дунд Цэнхэрийн голоос 1, Мөст сумаас 1, Булган голын эрэг дагуу 2, Үенч голоос 1, Барлаг голоос 3, Дамжиг уснаас 1, Хонгио голоос 1, Буянт голоос 1 дурсгалт газар тус тус илэрч олддоод байна. Эдгээрийн зарим нь доод палеолит, дээд палеолитын дурсгалуудтай нэг дороос олдсон нь залгамж шинжтэйг харуулна. Тэдгээр дурсгалаас дунд палеолитын чулуун зэвсэг үйлдвэрлэлийн чиг хандлагыг тодорхой харж болохуйц дурсгалуудыг доор төлөөлүүлэн авч үзлээ.

**Барлаг гол.** Ховд аймгийн Алтай сумын нутаг Барлаг багийн урдхан талд Барлаг голын зүүн эрэгт байрлах хоорондоо холгүйхэн орших гурван дурсгалт газраас дунд палеолитын үед холбогдох 236 чулуун зэвсгийн дурсгалыг 1984 онд МЗТСХЭ-ийн палеолитын судалгааны ангийн судлаачид илрүүлэн олсон байна. Барлаг-1-ээс 108, Барлаг-2-оос 80 (Зураг 5, 1, 10, 12), Барлаг-3-аас 48 чулуун эд өлөг цуглуулжээ.

Барлаг голын 1-р дурсгалт газрын үйлдвэрлэлийн анхдагч цуулалтын дотор леваллуагийн үлдэц (Зураг 5, 8, 9, 11, 13, 17) давамгайлж байгаа нь он цагийн хамаарлын асуудлыг тогтоох гол үндэс болсны дээр тэдгээр үлдцийн цуулалтын байдал, өргөнзалтас, үзүүрмэс голчлон цуулж байсан зэрэг нь дунд палеолитын нэлээд эртний шинжтэйг давхар харуулдаг. Дээрх үлдцүүдээс гадна дэвүүр маягийн цуулалтын зарчимт, цуулалтын нэг гадаргуут, цохилтын нэг талбайтай зэрэгцээ цуулалтын зарчимт үлдэц, радиаль үлдэц (Зураг 5, 15) бий.

Багаж зэвсгийн хувьд леваллуагийн залтас, леваллуагийн үзүүр мэс илүү олон тоотой байхаас гадна хянгар, өвөрмөц зэвсгүүд, хүнхэр ховилтой холтослуур зэвсэг тааралдана.

Барлаг голын дунд палеолитын дурсгал нь Монгол Алтайн нурууны чулуун зэвсэг

үйлдвэрлэлийн жишиг дурсгалд тооцогдох бөгөөд харьцангуй урт хугацааг дамжин туулсан леваллуагийн чиг хандлага бүхий бууц юм.

Судлаачид энэхүү дурсгалыг бусад газраас олдсон дурсгалуудын хувьд харьцуулах жишиг шаталбар болгон томьёолж иржээ. Барлагийн шаталбар нь одоогийн байдлаар мустьен хамгийн эртний дурсгал хэмээн тооцогдож байна. Он цагийн хувьд баримжаа байдлаар 133-50 мянган жилийн өмнөх үед холбогдуулан авч үзэж болохоор байна. Ингэхдээ эрчимтэй судалгаа хийгдэж, хөрш зэргэлдээх бүс нутгийн он цагийн хамаарлын асуудал ямар нэгэн байдлаар тодорхой болсон чулуун зэвсгийн бүлэг дурсгалуудтай харьцуулан авч үзсэн нь мэдээж юм. Барлагийн шаталбарын мустьен цогц дурсгалууд Уулын Алтайн Усть-Караколын чулуун зэвсгийн үйлдвэрлэлтэй ижилсдэг.

**Манхан-1.** Манхан сумын төвөөс хойш 3,5 км зайд, Дунд Цэнхэрийн (Төгрөг) голын зүүн эрэгт байрлах энэ дурсгалт газраас 1979 онд МЗТСХЭ-ийн чулуун зэвсгийн судалгааны анги дунд палеолитын үеийн 28 тооны чулуун зэвсгийг илрүүлэн олсон байна. Чулуун зэвсгүүдийн ихэнхийг хар өнгийн цахиуржсан чулуугаар хийсэн байв.

Манхан-1-ээс үлдэц харьцангуй олон тоогоор олдсоны ихэнх нь хөндлөн цуулалтын зарчмаар бэлдсэн нэг (Зураг 5, 5) болон хоёр цуулалтын гадаргуутай ажээ. Леваллуагийн үлдэц (Зураг 5, 4), бэлдэц (Зураг 5, 3) нэг, нэг байна.

Багаж зэвсгийн хувьд том хэмжээний хянгар давамгайлна. Ир гаргасан байдлаараа энэ төрлийн зэвсэг дотроо ялгагддаг. Хоёр хянгар хагас дугуйрсан байдлаар ирлэгдсэн бол нэг хянгарын хөндлөн, нөгөө хянгарын уртааш ирмэгийг тэгш холтчин ирлэсэн байна. Зууван гонзгой хайргаар хийсэн нэг үзүүртээ олон тооны хортон сэв суусан цохиур чулуу олдсон нь чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн арга ажиллагааг тандан тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Залтаснуудын хувьд бахим, том хэмжээтэй, дөрөв нь хоёрдогч. Сегмент хэлбэрийн цуулдаснууд хэмжээний хувьд уртавтар.

Энэ суурингаас олдсон леваллуагийн сонгодог хэлбэрийн үлдэц, сегмент хэлбэрийн цуулдас, том хянгар, залтаснууд нь дунд палеолитын үеийн чулуун зэвсгийн үйлдвэрлэлэх арга ажиллагааг тод илэрхийлэхийн зэрэгцээ багахан хэмжээний дархны газар байсныг илтгэнэ. Мөн түүнчлэн чулуун зэвсгүүдийн гадаргуу нь ихээхэн өгөршсөн байгаа нь он цагийг баримжаалах гол үндэслэл болсон юм.

**Хойд Цэнхэрийн гол-2.** Ховд аймгийн Манхан сумын нутаг Хойд Цэнхэрийн голын 2-р сууринаас олдсон чулуун зэвсгүүдээс гадаргуу нь

өгөршиж, бор саарал өнгөтэй болсон цахиуржсан чулуугаар хийсэн 129 эдлэл нь дунд палеолитын үед холбогдоно. Дурсгалт газрын чулуун зэвсэг үйлдвэрлэлийн анхдагч цуулалтын байдал бэлдэц, үлдцээр тод илэрхийлэгддэг. Бэлдцүүдийн дотор уртавтгар, зууван хэлбэрийн цохилтын талбайг налуу байдлаар бэлтгэн, ганц хоёр туршилтын, өргөн богиновтор цуулалт хийсэн эдлэлүүд тод ялгардаг (Зураг 5, 2).

Үлдцүүдийг авч үзвэл леваллуагийн хэв шинжит үлдэц давамгайлахын дээр олон талбайт, радиаль, дэвүүр маягийн зарчимт, хажуугийн нарийн талдаа цуулалт бүхий үлдцүүд нэлээдгүй бий. Үлдцийг засах явцад гарсан цуулдас, хоёрдогч цуулдас олон байгаа нь чулуун зэвсэг үйлдвэрлэлийн чиг хандлагын тодорхой шат дараалсан арга ажиллагааг танин мэдэхэд чухал ач холбогдолтой юм.

Багаж зэвсгийн хувьд хянгар зэвсэг голлоно. Тэдгээрийн ихэнхийн ирийг тэгш болон хотгор байдлаар нэг хажууд нь гаргасан байна. Бүх ирмэгийг ирлэсэн хянгар ч бий. Холтослуур зэвсгийн хүнхэр ховилыг нарийн ирлэж байжээ. Бусад зэвсгүүдийн хувьд хусуур, өвөрмөц зэвсгүүд, иртэй цуулдас, ялтас байна. Чулуун зэвсгийн цуглуулгад үйлдвэрлэлийн хаягдал болох залтас, ялтас цөөн тоотой.

Хойд Цэнхэрийн гол-2-ын чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн шинж байдал, чулуун зэвсгийн төрөл зүйл нь Манхан сумын нутгаас олдсон Манханы 1, 6, 7, 8, 11, 13, Хойд Цэнхэрийн голын 1, 3, Мөстийн 1-р дурсгалт газрынхтай бүхий л талаараа ижилсдэг. Энэ бүх дурсгалт газар нь чулуун зэвсэг үйлдвэрлэлийн леваллуагийн хөгжлийн чиг хандлага дээр суурилсан ажээ.

Ховд аймагт чулуун зэвсгийн судалгаа хийж эхэлсэн цагаас хойш илэрч олдсон дунд палеолитын үеийн дурсгалт газруудаас нийтдээ 1192 тооны чулуун зэвсгийн олдвор илэрч оллоод байна.

Чулуун зэвсэг үйлдвэрлэлийн цөм болсон анхдагч цуулалтын хэсэгт хамаарах эдлэлүүд нийт чулуун зэвсгийн дотор багагүй хувийг эзэлнэ (32.1%). Тэдгээрээс үлдэц үнэмлэхүй давамгайлж байна (нийт 160 ш буюу нийт анхдагч цуулалтын хэсгийн 41,8%). Үлдэц, бэлдцүүлийн дотор леваллуагийн сонгодог зарчимт (25 ш) болон радиаль цуулалтын зарчмаар (36 ш) цуулсан нь хамгийн олон тоотой байгаа юм. Энэ нь дунд палеолитын үед Ховд аймгийн нутаг дэвсгэрт амьдарч байсан эртний хүмүүсийн чулуун зэвсэг үйлдвэрлэл тухайн арга ажиллагаануудад тулгуурлаж байсныг илтгэнэ. Дээрх аргаас гадна хөндлөн цуулалтын арга, зэрэгцээ цуулалтын аргууд түлхүү хэрэглэгдэж байжээ. Хөндлөн цуулалтын аргаар бэлдсэн үлдцээс богинохон

залтаснууд авч байсан нь түүхий эдийг аль болох үр бүтээлтэй ашиглан, олон залтас авахыг зорьж байсан эртний хүний бүтээлч сэтгэхүйн хөгжлийн түвшинг илтгэн харуулдаг онцлогтой. Энэ хоёр аргыг хэрэглэхдээ цохилтын нэг талбайт, цуулалтын нэг гадаргуут үлдэц ашиглажээ.

Олон талбайт хайрган үлдэц (Зураг 5, 7) мэдэгдэхүйц (нийт үлдцийн 6,8%) байгаа нь доод палеолитын чулуун зэвсэг үйлдвэрлэлийн анхдагч цуулалтын арга ажиллагааны уламжлал тодорхой хадгалагдан байсныг гэрчилнэ.

Цохилтын нэг талбайт, цуулалтын нэг гадаргуут хайрган бэлдэц, үлдцүүдийн зарим нь чоппер зэвсэгтэй тун төстэй харагдах ба дунд палеолитын эхэн үед холбогдох Манхан-6 (Зураг 5, 16), Манхан-7 (Зураг 5, 14) дархны газруудаас голчлон олдсон байна.

Ховд аймгийн дунд палеолитын 29 дурсгалт газраас 23 төрлийн 444 багаж зэвсэг илэрч оллоод байна. Хамгийн олон тоотой нь төрөл бүрийн хянгар зэвсэг ажээ (126 ш). Бусад зэвсгүүдийн хувьд өвөрмөц зэвсэг (54 ш), чоппер (49 ш), шүдлэг иртэй зэвсэг (41 ш), леваллуагийн цуулдас (34 ш), иртэй залтас (26 ш), чоппинг (20 ш), хусуур (17 ш), холтослуур (165 ш) олон тоотой, үзүүр мэс (11 ш), иртэй ялтас (10 ш), харуул (8 ш), бифас (7 ш) цөөвтөр, цоолтуур (5 ш), зоруул (5 ш), хосолмол зэвсэг (4 ш), хутга (3 ш), сийлүүр (3 ш), цавчуур (3 ш) цөөхөн, ооль, кливер, мустьен үзүүр мэс, жадны гилбэр ганц ганц тоотой олдсон юм.

Цуулдасны үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээс залтас олон тоогоор олдсоноос гадна ялтас, сегментэн цуулдас, хагархай, ялтсан цуулдас, цуулалт бүхий хайрга тодорхой хэмжээгээр олдож судлагджээ.

Ховд аймгийн дунд палеолитын чулуун зэвсгийн дурсгалт газруудын чулуун зэвсгийн үйлдвэрлэл нэгдмэл байсан бөгөөд 135-45 мянган жилийн өмнөх үед холбогдох энэхүү үйлдвэрлэлийн үндсэн арга нь леваллуагийн цуулалтын арга ажиллагаанд суурилж байсан байна. Мөн радиаль цуулалтын арга, зэрэгцээ цуулалтын аргууд ч түгээмэл хэрэглэгдэж байжээ.

#### Дээд палеолит

Ховд аймгийн нутаг дэвсгэрээс дээд палеолитын үеийн дурсгалтай газар хамгийн их буюу 64 оллоод байна. Тэдгээрээс хоёр нь (Барлаг гол-1, Хойд Цэнхэрийн гол-2) доод, дунд палеолит, гурав нь дунд палеолит, нэг нь дунд палеолит болон мезолит, хоёр нь дунд палеолит болон неолит, хоёр нь мезолит, нэг нь мезо-неолит, хоёр нь неолитын үеийн дурсгалуудтай холилдон байдалтай байжээ. Дан ганц дээд палеолитын чулуун зэвсгийн үйлдвэрлэлийг илтгэх суурин 51 байна. Ховд аймгийн нутагт оршин буй дээд

палеолитын дээрх суурингуудаас 3212 тооны чулуун зэвсгийн олдвор түүвэрлэн цугларсан ажээ. Тэдгээр дурсгалаас дээд палеолитын чулуун зэвсэг үйлдвэрлэлийн чиг хандлагыг тодорхой харж болох дурсгалуудыг төлөөлүүлэн авч үзлээ.

**Манхан-5.** Ховд аймгийн Манхан сумын төвийн ойролцоо Хойд Цэнхэрийн гол, Дунд Цэнхэрийн (Төгрөг) голын бэлчирт байрлана. 1979 онд МЗТСХЭ-ийн чулуун зэвсгийн дурсгал судлах анги олсон. Энэ дурсгалт газраас хайрган чулуугаар хийсэн 231 эдлэл илэрч олдсон байна.

Энэ суурингийн үйлдвэрлэлийн анхдагч цуулалт нь цохилтын хоёр талбайт цуулалтын нэг гадаргуут, леваллуагийн (Зураг 6, 7), зэрэгцээ цуулалтын зарчимт, олон талбайт (Зураг 6, 13), призмэн, (Зураг 6, 8, 10) зэрэг төрлийн үлдцээр илэрхийлэгддэг. Тэдгээрийг хагархай хайрга, зарим тохиолдолд хаягдмал үлдцэн цохиур чулуу ашиглан хагалж цуулж байжээ. Ийм цохиур чулуу 5 ширхэг олдсон байна (Зураг 6, 2).

Олон төрлийн багаж зэвсгүүд илэрч олдсон. Тэдгээрээс иртэй залтас давамгайлна. Бусад зэвсгийн хувьд хянгар, хусуур, өвөрмөц хэлбэрийн зэвсгүүд, бифас, шүдлэг хүнхэр иртэй зэвсэг, леваллуагийн иртэй цуулдас, иртэй ялтаснууд байна.

Үлдэц, багаж зэвсгүүд төрөл зүйлийн хувьд олон янз, түүний дотор леваллуагийн үлдэц хэд хэд байгаа, иртэй өргөн ялтаснууд, шүдлэг хүнхэр иртэй зэвсгүүд олдсон нь энэ дурсгалт газрыг дээд палеолитын харьцангуй эрт үед холбогдохыг харуулдаг. Өөөрөр хэлбэл 40-35 мянган жилийн өмнөх үед холбогдоно. ОХУ-ын Денисовын агуй, Страшная агуй, Усть-Канийн агуй, Малая Сья, Варварина гора, Санний Мыс, Толбага, Кара-Бом зэрэг газруудын чулуун зэвсгийн үйлдвэрлэлтэй үлдэц болон багаж зэвсгийн хувьд адилсдаг нь он цаг тогтоох бас нэг үндэслэл болсон юм.

**Алтай-1.** Ховд аймгийн Алтай сумын төвөөс баруун урагш 4 км-т Бодончийн голын зүүн бие, Мэргэн уулын зүүн хойд бэлд орших энэ сууринг 1984 онд МЗТСХЭ-ийн палеолитын судалгааны анги нээн олж 207 чулуун зэвсэг цуглуулжээ [Петров, Зенин, 1987: 45-71].

Чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн анхдагч цуулалт харьцангуй олон тоотой үлдэц (31 ш) бэлдцээр (6 ш) тод томруун илэрхийлэгдэнэ. Тэдгээрийн дийлэнхийг зэрэгцээ цуулалтын зарчмаар (Зураг 6, 6, 9) бэлдсэн байгаа нь дээд палеолитын чулуун зэвсэг хийх аргын төгс илэрхийлэл юм. Бусад үлдэц нь шаантган (Зураг 6, 15) болон хөндлөн цуулалтын зарчимт залтас цуулахад зориулагдсан байдаг.

Багаж зэвсэг төрөл зүйлийн хувьд арван хэсэгт хуваагдана. Хамгийн олон тоотой нь харуул зэвсэг (14 ш) юм. Бусад зэвсгийн хувьд хянгар, хусуур,

иртэй ялтас, иртэй залтас, шүдлэг иртэй залтас, цүүц, чоппинг байна.

Уртавтар иртэй харуул олон тоотой олдсон нь энэ дурсгалт газрын үйлдвэрлэлийн тусгайлсан онцлог юм. Хянгар зэвсгийн (5 ш) хувьд нэгээс бусад нь бүгд дан иртэй. Ирний хэлбэрийн хувьд хотгор, тэгш, гүдгэр гэж ангилагдана. Нэг хянгар хайрган мөртэй бөгөөд гарт барихад их эвтэйхэн. Гадаргуу нь тодорхой хэмжээгээр элэгдсэн нэг хянгарын гурван талын ирмэгийг ирлэжээ. Хянгаруудыг залтсаар хийхээс гадна хавтгай чулуу, хагархай ашиглан хийсэн онцлогтой. Хусуур зэвсгийн (3 ш) нэгийн гурван талд ир гаргасан гурамсан хэлбэрийн төрөлд хамаарна. Нөгөө хоёр нь хажуугийн болон үзүүр иртэй.

Чоппинг зэвсгийн хувьд цүлхэгэр бөөртэй. Нэг үзүүрийг хоёр тал руу нь хагалж гүдгэр ир гаргасан. Бариул хэсэгт хожим цуулалт хийсэн байдал ажиглагдана.

Иртэй залтас (11 ш), ялтаснуудын (4 ш) үзүүр болон хажуу ирмэгүүдийг дотор болон гадна талаас нь холтлон ирлэжээ. Зургаан залтасны ирмэгийг шүдлэг маягаар ирлэж зассан байна.

Багаж зэвсгийн дотор ир гаргалгүй шууд тодорхой үйлд ашиглаж, түүний үр дүнд хурц ирмэг нь холтлогдож хэлтлэгдсэн анхдагч (4 ш), хоёрдогч цуулдас (17 ш), ялтас (3 ш), залтас (34 ш), хагархайнууд (4 ш) тааралдана.

Алтай-1 суурины чулуун зэвсгийн үйлдвэрлэл хэд хэдэн онцлогийг илтгэн харуулж байгаа ба юуны түрүүн голчлон хавтгай чулуу ашиглан хийсэн харуул зэвсэг олон байгаа нь аж ахуйн хэвшлийн өвөрмөц байдлыг тандах бололцоог олгоно. Мөн зориуд ир гаргаагүй үйлдвэрлэлийн хаягдал цуулдаснуудыг багаж болгон ашиглаж байсан нь энэ суурины бас нэг онцлог юм. Тухайн дурсгалт газрыг дээд палеолитын үед холбогдох суурин-дархны газар гэж тодорхойлон авч үздэг.

**Барлаг-1.** Доод, дунд палеолитын багаж зэвсгүүдтэй хамт нэг дороос олдсон, гадаргуу нь элэгдээгүй 32 чулуун зэвсэг дээд палеолитын үед холбогдоно. Ганц үлдэц олдсон нь цацарган цуулалтын зарчмаар хийгдсэн, хэмжээний хувьд жижиг.

Хэрэглээний багаж зэвсгийн дотор хянгар зонхилох ба тэдгээрийн 6 нь хөндлөн, 4 нь уртааш ирлэгдсэн. Гурван хянгарын бүх ирмэгийг ирлэжээ. Мөн мөртэй хянгар хоёр бий. Бусад зэвсгийн хувьд хусуур (5 ш), бифас (8 ш), өвөрмөц зэвсэг (3 ш) илэрсэн байна.

**Барлаг гол-3.** Алтай сумын нутагт орших энэ дурсгалт газраас хамгийн олон тоотой дээд палеолитын багаж зэвсэг олдсон юм. Чулуун зэвсэг хийх түүхий эдийнхээ яг дэргэд байгаа нь энэ дархны газрын чухал тал, бусдаас ялгарах өвөрмөц онцлог юм. Чулуун зэвсэг үйлдвэрлэлийн анхдагч



цуулалтыг илтгэн харуулах эдлэл давамгайлж (Зураг 6, 12), багаж зэвсэг тун цөөхөн олдсон байна.

**Барлаг гол-4.** Энэ дархны газраас 69 тооны чулууны зэвсгийн дурсгал олдсон юм. Чулуун зэвсгийн үйлдвэрлэл зэрэгцээ цуулалтад суурилжээ. Цуулалтын энэ аргыг ашиглан уртавтар, өргөн ялтас авч байв. Ийм ялтас авч байсан 3 тайрдсан үлдэц олдсон нь хэмжээний хувьд том, хавтгай чулууг шууд ашиглан цуулалт хийсэн байв. Цуулалтын нэг гадаргуут, цохилтын нэг талбайг үлдцээс мөн л өргөвтөр ялтас цохиж авсан зэрэгцээ цуулалтын ором мэдэгдэнэ.


Леваллуагийн ирлэсэн цуулдас олдсон нь дунд палеолитод өргөн хэрэглэгдэж байсан энэ арга уламжлагдан хэрэглэгдэж байсныг баталж байна.

Багаж зэвсгийн дотор хянгар голлоно. Барлаг 4-р суурингийн хянгарын өвөрмөц онцлог нь хавтгай чулууг шууд ашиглан, ирлэж хийж байсанд оршдог. Хавтгай чулуудыг хайнгадуухан ирлэж огтлох, зүсэх зэвсэг хийснээс гадна залтас, хоёрдогч залтсыг ирлэлгүйгээр шууд ашиглаж байжээ. Ийнхүү ир гаргалгүй ашиглаж байсан ором мөртэй залтас, хоёрдогч залтас 16 олдсон байна. Ир гаргахдаа хагалж таших, ирлэх хоёр аргыг ашиглаж байсан нь тодорхой болсон юм.

Энэ дурсгалт газраас төрөл зүйлийн хувьд олон багаж зэвсэг, үлдэц, техникийн цуулдас олон илэрсэн нь дархны газар байсныг харуулж байна.

Ховд аймгийн дээд палеолитын дурсгалуудын ихэнх нь хүн удаан хугацаагаар амьдарч ирсэн бууц суурин болон түр хугацаанд буусан буудал газар ажээ. Дархны газар цөөхөн хэдий ч Барлаг гол-3, Ярант гэсэн энэ бүс нутгийн дээд палеолитын жишиг болохуйц томоохон дурсгалт газар бий. Тодорхой хугацаанд суурьшин, багаж зэвсгээ хийж байсан суурин-дархны газар хэд хэд байна. Ийм газрын тоонд Алтай-4, Барлаг-4 хамаарна.

1966 онд илэрч судлагдсан Буянт голын гүүр, Цэнгэлдэх хүрээлэнгийн орчим, Рашааны гол, Зумьяа голын бууц суурингуудаас чухам хэдий



Зураг 6. Ховд аймгийн нутгаас олдсон дээд палеолитын чулуун зэвсгүүд 1, 2 – цохиур чулуу; 3 – бэлдэц; 4-15 – үлдэц (1 – Мөст-6; 2, 7, 8, 10, 13 – Манхан-5; 3 – Цэцэг-4; 4 – Ярант; 5, 14 – Цэцэг-1; 6, 9, 15 – Алтай-1; 11, – Уенч-3; 12 – Барлаг-3) (Деревянка нар 1990).

тооны чулуун зэвсгийн олдвор хэрэглэгдэхүүн олдсон нь тодорхой бус, 1979 онд судлагдсан Цэцэг сумын Уушгийн баруун хоолойн өвөлжөө, Чандмань хар үзүүр, Харганатын ам, Дамжиг ус, Өвдөг түнхийн чулуун зэвсгийн олдворуудыг боловсруулж, судалгааны эргэлтэд бүрэн оруулаагүй байна.

Бусад 57 дурсгалт газраас олдсон 2822 тооны чулуун зэвсгийн олдворууд дотор анхдагч цуулалттай холбоотой эдлэлүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр байгаа юм (28%-764 ш). Тэдгээрийн дотор бэлдэц (Зураг 6, 3), үлдэц тооны хувьд олон байна (440 ш). Үлдэц 298 ш байгаа ба энэ нь анхдагч цуулалт дотор 39%-ийг эзэлж байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт юм. Үлдцүүдийг төрөлжүүлэн авч үзвэл цохилтын

нэг талбайт, цуулалтын нэг гадаргуут үлдэц давамгайлна (Зураг 6, 4, 11). Тайрдсан, зэрэгцээ цуулалтын зарчимт үлдцүүд (Зураг 6, 14) ч олон тоотой байна. Бусад үлдцүүдийн хувьд хайрган, олон талбайт, хөндлөн цуулалтын зарчимт, таргил, хоёр талбайт (Зураг 6, 5), цацарган цуулалтын зарчимт, леваллуагийн зэрэг олон төрөлд хуваагдана. Ховд аймгийн нутаг дэвсгэрээс олдсон дээд палеолитын дурсгалуудын анхдагч цуулалт, тэр дундаа бэлдэц, үлдцэд тулгуурлан чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн ерөнхий төлөв байдлыг тодорхойлон үзвэл зэрэгцээ цуулалтын арга ажиллагаа зонхилж байсныг харж болно. Энэ нь Евразийн өргөн уудам дайд тухайн үед тархсан чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн чиг хандлага, хөгжлөөс хазайгаагүй, чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн хөгжлийн шинэ арга ажиллагаа Монгол Алтайн нурууны өвөр хэсэгт нэгэн зэрэг нэвтэрсэн байсны илэрхийлэл болно.

Дээд палеолитын эхэн үеийн дурсгалууд болох Манхан-9, Тахилтын хотгор, Зах булаг, Цахирын үзүүр зэрэг бууц сууринаас леваллуагийн арга ажиллагаатай холбоотой багаж зэвсгүүд олдсон нь өмнөх үеийн чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн арга ажиллагаа эхэн үедээ зэрэгцэн оршиж аажмаар шинэ аргаар солигдсоны баталгаа юм. Дээд палеолитын хөгжингүй шатанд призмэн цуулалтын арга нэвтэрч цаашид боловсруулагдан хөгжсөн нь цөөн тооны призмэн цуулалтат үлдэц, бэлдцээс тод харагдана.

Ховд аймгийн дээд палеолитын бууц, сууринуудаас нийтдээ 22 төрлийн 748 тооны багаж зэвсэг олдсон байна. Тэдгээрийн дотор иртэй залтас (239 ш), хянгар (144 ш) бусдаас давамгайл олон тоотой ажээ. Ооль, тэгш ирт цавчуур зэвсэг ганц ганц, үзүүр мэс (2 ш), хатгуур (2 ш), сийлүүр (3 ш), чоппер (2), цүүц (4 ш), хутга (5 ш), хайрган хугадас (6 ш), зоруул (8 ш), холтослуур (11 ш), иртэй хавтгай чулуун зэвсэг (11 ш) цөөн тоогоор, харуул (23 ш), леваллуагийн цуулдас (26 ш), бифас (28 ш) их, хусуур (49 ш), иртэй ялтас (48), өвөрмөц зэвсэг (49 ш), шүдлэг зэвсэг (68 ш) харьцангуй их байна.

Цуулдасны үйлдвэрлэлийн хэсэгт залтас үнэмлэхүй давамгайлна (1036 ш). Залтаснууд дотроо анхдагч, хоёрдогч, энгийн хэмээн ангилагдана. Түүнчлэн ялтас, хагархай, ялтсан цуулдас, сегментэн цуулдас тодорхой тоогоор илэрсэн юм.

Ховд аймгийн нутгаас олдсон дээд палеолитын үеийн дурсгалуудад тодорхой ялгаатай тал, хэв шинжийн өөр өөр онцлог талууд байгаа хэдий ч 45-12 мянган жилийн өмнөх үед холбогдох чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн хөгжлийн чиг шугам нэгдмэл байсан байна.

### Мезолит, неолит

Мезолит, неолитын үед холбогдох дурсгалт газрууд палеолитын үеийн дурсгалуудыг бодвол цөөн тоотой хэдий ч тэдгээрт голоцены үеийн чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн арга барил тод томруун тусгалаа олжээ. Хамгийн анх газар зүйч О.Намнандорж Үенч сумын нутаг Дамжиг уснаас палеолитын дурсгал зүйлийн хамт неолитын 7 ширхэг багаж зэвсэг олж байв. Тэр үеэс хойш мезолит, неолитын үеийн чулуун зэвсэгтэй газар 15 илэрч судлагдаад байна. Чулуун зэвсгийн олдворууд газрын хөрсөн дээрээс илээр олдсон тул мезолит, неолитын зааг ялгааг тодруулахад тодорхой бэрхшээлтэй байжээ. Гэсэн хэдий ч тухайн дурсгалт газрыг судалсан судлаачид зохих хэмжээгээр ангилан ялгасан байна. Ингэхдээ дээд палеолитын дурсгалтай хамт нэг газраас олох бичил чулуун зэвсгүүдийг мезолитын үед холбогдуулан үзэх хандлага түлхүү хэрэглэсэн байдаг.

Судлаачдын ангилан ялгаснаар голоцены үеийн дурсгалуудыг мезолит, мезо-неолит, неолит гэсэн гурван үндсэн хэсэгт хуваан, ангилсан байдаг. Эхний хэсэгт мезолитын дурсгалт газар хамаарах ба тэдгээрийн ихэнх нь дээд палеолитын олдвор хэрэглэгдэхүүнтэй нэг дор оршиж байв. Энэ хэсэгт 1966 онд илэрсэн Мөстийн суурин, 1984 онд олдсон Алтай-3, 2008 онд судлагдсан Бугатын үзүүр—III дурсгалт газар хамаарна.

Дан мезолитын ганц суурин байгаа нь Үенч-8 юм. Дараагийн мезолит, неолитын үйлдвэрлэлийн шинжийг хадгалсан дурсгалд Булган-1, Үенч-9, Үенч-10, Үенч-11 дурсгалт газрууд хамаарна. Харин цэвэр неолитын сууринд Булган-5, Булган-6, Барлаг гол-6, Хаалгач уул зэрэг таван дурсгал холбогдоно.

Дээд палеолитын олдворуудтай хамт неолитын дурсгалууд ч олох тохиолдол байна. Ийм газрын тоонд Их Цахир, Дамжиг ус, Булган-2 хамаарна.

**Үенч-8.** Үенч сумаас баруун тийш 5 км зайтай Хөвийн хөндийд оршдог. Энэ дурсгалт газрын олдвор хэрэглэгдэхүүн өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой. Энэ нь улаан өнгийн цахиурлаг хавтгай чулуудыг зэвсэг хийх гол түүхий эдийн нэг болгон ашиглаж байсанд оршино. Үлдцүүд том биш цуулдас авахад зориулагдаж байжээ. Багаж зэвсгийн хувьд хусуур зэвсэг голлох ба хэмжээний хувьд жижиг, зургаан төрөл зүйлд хуваагддаг. Иртэй залтас, ялтас олон тоотой илэрсэн. Тэдгээрээс харахад ихэнхэд нь сийлүүрийн ир гаргаж байсан байна. Түүний зэрэгцээ сийлүүр зэвсэг, хусууртай хослуулсан сийлүүр зэвсэг олдсон нь энэ дурсгалт газрын үйлдвэрлэлийн үүрэг зориулалтын байдлыг тандан үзэхэд ихэд тустай юм. Энэ суурингийн чулуун зэвсгүүд дээд палеолитоос эрс ялгагдах ба чулуун зэвсэг хийхдээ

ашиглаж байсан түүхий эдийн сонголт сайжирч, хэмжээ жижгэрч, хусуур зэвсгийн төрөл зүйл олширч, сийлүүрийн эзлэх хувь их байгаа зэрэг нь мезолитын үед холбогдуулан үзэх үндэслэл болсон.

**Үенч-9.** Үенч сумаас баруун тийш 6 км зайтай Хөвийн хөндийд оршдог. Энд 30 х 40 м хэмжээтэй газраас 111 чулуун зэвсгийн зүйл түүвэрлэсний ихэнх нь залтас, ялтас байжээ. Үлдэц хоёрхон олдсон нь тайрдсан болон призмэн цуулалтаар боловсруулагдсан байв. Үлдцийг засах явцад гарсан цуулдасны (12 ш) ирмэг холтлогдож сэлтлэгдсэн байдалтай байх ба энэ нь багаж зэвсгийн зориулалтаар ашиглаж байсны баталгаа юм. Мөн олон тооны ирлэсэн залтас, ялтас байгаагийн зэрэгцээ ганц л хянгар зэвсэг олдсон байна.

**Булган-5.** Ховд аймгийн Булган сумын нутаг, сумын төвөөс баруун тийш 20 км зайтай Булган голын зүүн эрэгт байрлана. Энд Булган голруу шахаж орсон элсэн манханы хаяа хөвөө, нүцгэрсэн хэсгээс ногоон, хар саарал, хар өнгийн цахиур, ногоон, саарал, цайвар саарал өнгийн хас, манаар хийсэн 183 тооны чулуун зэвсэг олджээ [Нохрина 1987: 103-109].

Булган-5-ын чулуун зэвсгийн үйлдвэрлэл бичил ялтсан цуулалтын арга ажиллагаанд суурилжээ. Анхдагч цуулалт нь шаантган, тайрдсан үлдцээр илэрхийлэгдэхийн дээр залтас (38 ш), ялтас (85 ш), үлдэц хэлбэрийн цуулдас (2 ш), хавирган цуулдас (2 ш), босоо цуулдас (2 ш), хөндлөн цуулдас (7 ш) зэрэг бичил жижиг хэмжээтэй цуулдаснууд голчилно. Бичил ялтаснуудыг голчлон шовх үлдэц болон шаантган үлдцээс цуулсан байх ба голчлон ясан хутганы зуулга ир болгон ашиглаж байжээ.

Багаж зэвсгийг төрөлжүүлэн ангилвал, өвөрмөц зэвсэг, хусуур, сийлүүр, үзүүрийг мохоож ирлэсэн ялтас, иртэй ялтас, иртэй залтас байна. Ялтаснуудыг ирлэхдээ голлон дотор талаас нэг ирмэгийг холтлон, хэлтлэн, эмтлэн ирлэжээ. Цуглуулсан олдвор дотор хоёр нүдүүр чулуу байгаа нь аж ахуйн хэвшлийн онцлогийг тандах бололцоо олгоно.

Багаж зэвсгийг бичил ялтсаар хийж байсны дээр, зуулга зэвсэг олон тоогоор олдож байгаа нь энэ төрлийн зэвсэг хийх тусгай зориулалт бүхий суурин-дархны газар байсан байж болохоор байна.

**Барлаг гол-6.** Алтай сумын Барлаг багийн нутаг Барлаг голын зүүн эрэгт байх уулын баруун ар хормойд байрлана. Энэ дурсгалт газраас 12 тооны неолитын багаж зэвсэг олсоны дотор шовх үлдэц, үлдэц засахад гарсан цуулдас, ялтас, залтсаар хийсэн зэвсэг (5 ш), өвөрмөц зэвсэг, залтас (4 ш) байсан байна. Шовх үлдцээс олон тооны бичил ялтас гүйцэд авсан байв. Он цагийн хувьд неолитын хөгжингүй үед холбогдоно.

Ховд аймгийн нутаг дэвсгэрээс олдсон мезолит, неолитын үед холбогдох 15 дурсгалт газар илэрсэн бөгөөд тэдгээрээс 539 ширхэг чулуун багаж зэвсэгүүд олджээ. Дээрх дурсгалт газруудаас хамгийн багадаа нэг газраас 2, их нь 183 тооны олдвор хэрэглэгдэхүүн цуглуулсан байна.

Булган-5, Үенч-8, Үенч-9-ийн чулуун зэвсгийн үйлдвэрлэл хоорондоо тун төстэй байгаа ч тодорхой ялгамж байгаа нь чулуун зэвсэг хийх арга барилын залгамж шинж чанарыг илтгэн харуулж байгаа явдал юм.

Ховд аймгийн нутаг дэвсгэрээс илэрч олдсон мезолит, неолитын чулуун зэвсгийн дурсгалууд 10-6 мянган жилийн өмнөх үед холбогдоно.

### Дүгнэлт

Ховд аймгийн нутаг дэвсгэрт чулуун зэвсгийн судалгаа хийгдсэн цаг хугацаанаас хойш өнөөдрийн байдлаар 102 дурсгалт газар нээгдэж, судлагдан судалгааны эргэлтэд оржээ. Тэдгээр дурсгалт газруудаас 5000 гаруй тооны чулуун зэвсгийн эд өлөг олдсон байна.

Ховд аймгийн нутагт доод палеолитын үеэс неолитын үе хүртэл эртний хүмүүс үе дамжин амьдран сууж байсан нь чулуун зэвсгийн олдвор хэрэглэгдэхүүнээр батлагдаж байна.

Хамгийн анх 700 000 жилийн тэртээгээс эхлэн тус аймгийн нутаг дэвсгэрт нэн эртний хүний нэгэн зүйл болох *Homo erectus* идэвхтэй амьдран байсан нь Үенч (Үенч-1, Үенч-4, Үенч-6), Хойд Цэнхэрийн гол (Хойд Цэнхэрийн гол-2, Манхан-4), Барлаг (Барлаг-1, Барлаг-5), Уртын сайрын голын (Мөст-3) хөндийгөөс илэрч олдсон чулуун зэвсгийн дурсгалуудаар батлагдаж байна. Чулуун зэвсгийн үйлдвэрлэл талаас нь авч үзвэл хайрган зэвсгийн арга давамгайлах бөгөөд леваллуагийн цуулалтын арга үүсэж, бүрэлдэн хөгжсөн нь ихэнх дурсгалт газраас энэ төрлийн үлдэц тодорхой тоогоор олдсоноос тод харагдана. Судалгааны өнөөгийн байдлаас үзэхэд Ховд аймгийн доод палеолитын үе 700–135 мянган жилийн өмнөх цаг хугацаанд холбогдоно.

Дунд палеолит буюу хуучин чулуун зэвсгийн дунд үе 135 мянган жилийн тэртээд эхэлж 45 мянган жилийн өмнөх хүртэлх цаг хугацаанд үргэлжилжээ. Энэ үеийн чулуун зэвсгийн үйлдвэрлэлийг тод томруун илэрхийлэх 28 дурсгалт газар илэрч оллоод байна. Дээрх цаг хугацаанд эртний хүний удам зүйд томоохон өөрчлөлт гарсан бөгөөд үүнтэй уялдан чулуун зэвсгийн үйлдвэрлэл ч хурдацтай хөгжсөн нь тодорхой аж. Доод палеолитын дунд, сүүл үед эхлэл нь тавигдсан леваллуагийн цуулалтын арга улам боловсронгуй болж, өргөн хүрээтэй тархсан нийтлэг хандлага Ховд аймгийн дунд палеолитын бүх дурсгалуудад тод ажиглагдаж байна.



Ховд аймгийн нутгаас хамгийн олон тоогоор дээд палеолитын үеийн дурсгалууд илэрч олдсон байна. Нийт жаран нэгэн дээд палеолитын бууц, суурин, дархны газар илэрч олноор байгаа билээ. Тус бүс нутагт лавтай 45-40 мянган жилийн тэртээ орчин үеийн хүн (*Homo sapiens*) тархан нутаглаж эхэлсэн бөгөөд энэ үйл явц тухайн үеийн чулуун зэвсгийн үйлдвэрлэлд тод томруун тусгалаа олсны баталгаа нь дурсгалт газрууд олон тоогоор олдож байгаа явдал юм.

Дунд палеолитоос дээд палеолитод шилжих үе, дээд палеолитын эхэн шатанд өмнөх үеийн үйлдвэрлэлийн арга хэсэгхэн хугацаанд зэрэгцэн оршиж байсан бөгөөд аажмаар ялтсан цуулалтын шинэ аргаар солигдож, энэ шинэ арга улам боловсрогдон, нэг чигтэй хөгжсөн нь Ховд аймгийн дээд палеолитын дурсгалт газруудын олдвор хэрэглэгдэхүүнээс баттай мэдэгдэнэ.

Ховд аймгийн нутаг дэвсгэрээс илэрч олдсон чулуун зэвсгийн дурсгалууд бүгд газрын хөрсөн дээрээс ил байдалтай олдсон тул өөр өөр цаг үеийн дурсгалууд нэгдорхоорондоо холилдон байдалтай олох тохиолдол түгээмэл юм. Энэ онцлог шинж мезолит, неолитын үеийн дурсгалуудад нийтлэг ажиглагдана. Өнөөгийн судалгааны хүрээнд Ховд аймгийн нутгаас нийтдээ 16 мезолит, неолитын үеийн дурсгалт газар олноор байна. Палеолитын үеийн дурсгалаас энэ үеийн гол ялгагдах шинж нь мэдээж багаж зэвсгийн хэмжээ жижгэрч, төрөл зүйл нь олон болсноор ялгарахын зэрэгцээ анхдагч цуулалт, багаж зэвсгийн төрөл зүйл бүхий л талаар нэгдмэл байгаа явдал юм.

Эцэст нь дүгнэн хэлэхэд Ховд аймгийн нутгаас илэрч олдсон доод палеолитын үеэс мезолит, неолитын үе хүртэлх цаг хугацаанд хамаарах дурсгалт газруудын чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн хөгжлийн чиг хандлага нь нэгдмэл, залгамж чанартай байжээ.

#### Ном зүй

**Деревянко нар, 1984** - А.П.Деревянко, Д.Дорж, В.Е.Ларичев, С.В.Маркин, В.Т.Петрин. Археологические исследования в Монголии. Памятники каменного века (Общие сведения). Новосибирск, 1984. т. 14-16.

**Деревянко нар, 1985** - А.П.Деревянко, Д.Наваан, В.П.Алексеев, Р.С.Васильевский, В.Е.Ларичев. Археологические исследования в Монголии в 1984 году. – Известия СО РАН СССР. Серия истории, филологии и философии. №14. Вып.3 Новосибирск, 1985. т. 49-55.

**Деревянко нар, 1986а** – А.П.Деревянко, Д.Дорж, Р.С.Васильевский, В.Е.Ларичев, В.Т.Петрин. Археологические исследования в Монголии. Район сомонов Муст и Цэцэг Кобдоского аймака. Новосибирск, 1986.

**Деревянко нар, 1986б** – А.П.Деревянко, Д.Дорж, Р.С.Васильевский, В.Е.Ларичев, В.Т.Петрин. Археологические исследования в Монголии. Кобдоский аймак, Манхан 1-7. Новосибирск, 1986.

**Деревянко нар, 1986в** – А.П.Деревянко, Д.Дорж, Р.С.Васильевский, В.Е.Ларичев, В.Т.Петрин. Археологические исследования в Монголии. Кобдоский аймак, Манхан 8-14. Новосибирск, 1986.

**Деревянко, Петрин, 1987** - А.П.Деревянко, В.Т.Петрин. Комплекс каменной индустрии с южного фаса Монгольского Алтая. – Археология, этнографии и антропология Монголии. – Новосибирск, 1987. Тал 5-27.

**Деревянко нар, 1990** - Деревянко, А.П., Дорж, Д., Васильевский, Р.С., Ларичев, В.Е., Петрин, В.Т., Девяткин, Е.В., Малаева, Е.М.(1990) Палеолит и неолит Монгольского Алтая. – Новосибирск, 1990.

**Деревянко, 2017** - А.П.Деревянко. Три глобальные миграции человека в Евразии. Том II. Первоначальное заселение человеком Северной, Центральной и Восточной Азии. – Новосибирск, 2017.

**Доржсүрэн, 1957** - Ц.Доржсүрэн. БНМАУ-ын нутаг дахь чулуун зэвсгийн үеийн судлалын байдал. УБ., 1957, т. 9.

**Дроздов нар, 2001** - Н.И.Дроздов, Ц.Баасандорж, Е.В.Артемьев, А.Л.Зайка, В.И.Макулов, В.П.Чеха, Х.Цэдэв, М.Ганболд, Ц.Дашцерэн. археологические исследования в Западной Монголии (Комплексная экспедиция КГПУ, ИАиЭ СО РАН и Ховдинский филиал МонГУ). Проблемы археологии, этнографии, антропологии Сибири и сопредельных территорий. Новосибирск, 2001. Тал 66-71.

**Дроздов нар, 2002** - Н.И.Дроздов, Ц.Баасандорж, Е.В.Артемьев, А.Л.Зайка, В.И.Макулов, В.П.Чеха, Х.Цэдэв, М.Ганболд, Ц.Дашцерэн. Результаты археологических исследований в Западной Монголии в 2001 году. – Научный ежегодник КГПУ. Красноярск, 2002. Т.1, вып. 3. Тал 198-233.

**Дроздов нар, 2003** - Н.И.Дроздов, Ц.Баасандорж, Е.В.Артемьев, А.Л.Зайка, В.И.Макулов, В.П.Чеха, Х.Цэдэв, М.Ганболд, Ц.Дашцерэн. Работы комплексной экспедиции в Западной Монголии в 2001 году. – Природные условия, история и культура Западной Монголии и сопредельных регионов. Томск, 2003. Тал 155-156.

**Окладников, Ларичев, 1967** - А.П.Окладников, В. Е.Ларичев. Археологические исследования в Монголии в 1964 и 1966 гг. – Изв. СО АН СССР. Сер. обществ, наук. 1967. № 6, вып. 2.

**Петрин, 1987** - В.Т. Петрин. К проблеме

классификации каменного века Монголии. – Археология, этнографии и антропология Монголии. – Новосибирск, 1987. Тал 28-44.

**Петрин, 1991** - В.Т.Петрин. Палеолит Западной Монголии. (шинжлэх ухааны доктор хамгаалсан диссертаци). – Новосибирск, 1991.

**Петров, Зенин, 1987** - Петров, В.Г., Зенин, В.Н. (1987) Индустрия палеолитических памятников левобережья долины реки Бодончин-Гол. – Археология, этнографии и антропология Монголии.- Новосибирск, 1987. Тал 45-71.

**Цэвээндорж 1980** - Д.Цэвээндорж. 1979 оны МЗТСХЭкспедицийн чулуун зэвсэг судлах ангийн тайлан, УБ., 1980.

**Jabert нар** - J.Jabert, P.-H.Jiscard, Z.Batsaikhan, D.Erdenebaatar, Ch.Servelle. Contribution à la connaissance du paleolithique de Mongolie: Étude de sites de l'aimak de Hovd (Altai, Mongol). – L'Anthropologie, (Paris). Tome 101 (1997), № 3. Pp. 419-447.


**Тишкин нар, 2008а** - А.А.Тишкин, Б.Нямдорж, Н.Н.Серегин, Ч.Мунхбаяр. Плановые археологические обследования в долине Буянта (Западная Монголия). - Теория и практика археологических исследований. №4). Барнаул, 2008. Тал 68-69.

**Тишкин нар, 2008б** - А.А.Тишкин, Б.Нямдорж, Н.Н.Серегин, Ч.Мунхбаяр. Плановые археологические обследования в долине

Буянта (Западная Монголия). – Эрдэм шинжилгээний бичиг (Нийгэм, хүмүүнлэгийн ухаан). ХИС. НХУС. №1 (13). Ховд, 2008. Тал 63-64. **Кунгуров, Тишкин, 2008** - А.Л.Кунгуров, А.А.Тишкин. Местонахождение каменных артефактов около г.Ховда. - Теория и практика археологических исследований. №4). Барнаул, 2008. Тал 73-84.

**Семибратов, Тишкин, 2016** - В.П.Семибратов, А.А.Тишкин. Новые объекты каменного века на территории Монгольского Алтая. - Теория и практика археологических исследований. №2 (14). Барнаул, 2016. Тал 94-108.

**Цэрэндагва нар, 2016** - Я.Цэрэндагва, С.Далантай, Г.Олзбаяр. Ховдаимгийн Эрдэнэбүрэн сумын нутаг Хонгио гол, Хавцалын чулуун зэвсгийн дурсгалт газарт хийсэн судалгааны ажлын тайлан. – УБ., 2016.



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>

№	Дурсгалын нэр	Сум	Олсон судлаач, он	Чулуун зэвсгийн тоо (ш)	Он цаг
1	Дамжигийн ус	Үенч	О.Намнандорж, 1953	100	Дунд палеолит (7 ш) Дээд палеолит (86 ш) Неолит (7 ш)
2	Өвдөг түнх	Үенч	О.Намнандорж, 1953	50	Дээд палеолит
3	Цэнгэлдэх хүрээлэн	Жаргалант	МЗХЧЗСЭ 1966	?	Палеолит
4	Буянт голын гүүр	Жаргалант	МЗХЧЗСЭ 1966	?	Палеолит
5	Рашааны гол	Жаргалант	МЗХЧЗСЭ 1966	?	Палеолит
6	Зумьяагийн гол	Мянгад	МЗХЧЗСЭ 1966	?	Палеолит
7	Бор Өвдгийн бууц	Манхан	МЗХЧЗСЭ 1966	?	Дунд палеолит
8	Цэцэг-1	Цэцэг	МЗХЧЗСЭ 1966	12	Дээд палеолит (ЧЗ дээрх тэмдэглэгээ: Коб/Ц-1, 66/1-12)
9	Цэцэг-2	Цэцэг	МЗХЧЗСЭ 1966	16	Дээд палеолит (ЧЗ дээрх тэмдэглэгээ: Коб/Ц 2, 66/1-16)
10	Цэцэг-3	Цэцэг	МЗХЧЗСЭ 1966	10	Дээд палеолит (ЧЗ дээрх тэмдэглэгээ: Коб/Ц 3, 66/1-10)
11	Цэцэг-4	Цэцэг	МЗХЧЗСЭ 1966	9	Дээд палеолит (ЧЗ дээрх тэмдэглэгээ: Коб/Ц 4, 66/1-10)
12	Мөст	Мөст	МЗХЧЗСЭ 1966	167	Палеолит (150 ш) Мезолит (17 ш) (ЧЗ дээрх тэмдэглэгээ: К/М,Ц, 66/1-167)
13	Хаалгач уул	Ховд	МЗХЧЗСЭ 1966	?	Неолит
14	Харганатын ам	Манхан	МЗХЧЗСЭ 1966	5	Дээд палеолит
15	Чандмань Хар үзүүр	Мянгад	МЗТСХЭ 1979	47	Дээд палеолит
16	Мөст-1 (Улаан толгой)	Мөст	МЗТСХЭ 1979	20	Дунд палеолит (ЧЗ дээрх тэмдэглэгээ: Х/М-1, 79/1-20)
17	Мөст-2 (Бооржийн гол)	Мөст	МЗТСХЭ 1979	53	Дээд палеолит (ЧЗ дээрх тэмдэглэгээ: Коб/М-2, 79/1-50)
18	Уушигийн баруун хоолойн өвөлжөө	Цэцэг	МЗТСХЭ 1979	202	Дээд палеолит



19	Манхан-1	Манхан	МЗТСХЭ 1979	33	Дунд палеолит (28 ш) Дээд палеолит (3 ш) Неолит (2 ш)
20	Манхан-2	Манхан	МЗТСХЭ 1979	25	Дээд палеолит
21	Манхан-3	Манхан	МЗТСХЭ 1979	18	Дээд палеолит
22	Манхан-4	Манхан	МЗТСХЭ 1979	27	Доод палеолит
23	Манхан-5	Манхан	МЗТСХЭ 1979	231	Дээд палеолит
24	Манхан-6	Манхан	МЗТСХЭ 1979	22	Дунд палеолит
25	Манхан-7	Манхан	МЗТСХЭ 1979	10	Дунд палеолит
26	Манхан-8	Манхан	МЗТСХЭ 1979	21	Дунд палеолит
27	Манхан-9	Манхан	МЗТСХЭ 1979	8	Дээд палеолит
28	Манхан-10	Манхан	МЗТСХЭ 1979	27	Дээд палеолит
29	Манхан-11	Манхан	МЗТСХЭ 1979	35	Дунд палеолит
30	Манхан-12	Манхан	МЗТСХЭ 1979	7	Дунд палеолит
31	Манхан-13	Манхан	МЗТСХЭ 1979	39	Дунд палеолит
32	Манхан-14	Манхан	МЗТСХЭ 1966	21	Дээд палеолит
33	Их Цахир	Манхан	МЗТСХЭ 1983	64	Дээд палеолит (31 ш) Неолит (33 ш) (ЧЗ дээрх тэмдэглэгээ: Коб/М5, 83/1-64)
34	Манхан-15	Манхан	МЗТСХЭ 1983	8	Дээд палеолит (ЧЗ дээрх тэмдэглэгээ: Коб/М1, 83/1-8)
35	Манхан-16	Манхан	МЗТСХЭ 1983	17	Дээд палеолит (ЧЗ дээрх тэмдэглэгээ: Коб/М2, 83/1-17)
36	Манхан-17	Манхан	МЗТСХЭ 1983	18	Дээд палеолит (ЧЗ дээрх тэмдэглэгээ: Коб/М3, 83/1-18)
37	Манхан-18	Манхан	МЗТСХЭ 1983	16	Дээд палеолит (ЧЗ дээрх тэмдэглэгээ: БУ/М4, 83/1-16)
38	Манхан-19	Манхан	МЗТСХЭ 1983	12	Дээд палеолит (ЧЗ дээрх тэмдэглэгээ: Коб/М9, 83/1-12)
39	Манхан-20	Манхан	МЗТСХЭ 1983	10	Дээд палеолит (ЧЗ дээрх тэмдэглэгээ: Коб/ ХЦА 2, 83/1-10)

40	Манхан-21	Манхан	МЗТСХЭ 1983	14	Дээд палеолит (ЧЗ дээрх тэмдэглэгээ: Коб/М 7, 83/1-14)
41	Манхан-22	Манхан	МЗТСХЭ 1983	48	Дээд палеолит (ЧЗ дээрх тэмдэглэгээ: Коб/М8, 83/1-48)
42	Манхан-23	Манхан	МЗТСХЭ 1983	5	Дээд палеолит (ЧЗ дээрх тэмдэглэгээ: Коб/ХЦ 3, 83/1-5)
43	Манхан-24	Манхан	МЗТСХЭ 1983	3	Дээд палеолит (ЧЗ дээрх тэмдэглэгээ: Коб/ХЦ 1, 83/1-3)
44	Манхан-25	Манхан	МЗТСХЭ 1983	5	Дээд палеолит (ЧЗ дээрх тэмдэглэгээ: Коб/ХЦ 2, 83/1-5)
45	Хойд Цэнхэрийн гол-1	Манхан	МЗТСХЭ 1983	47	Дунд палеолит (ЧЗ дээрх тэмдэглэгээ: Коб/ ХЦА, 83/1-47)
46	Хойд Цэнхэрийн гол-2	Манхан	МЗТСХЭ 1983	158	Доод палеолит (22 ш) Дунд палеолит (129 ш) Дээд палеолит (7 ш) (ЧЗ дээрх тэмдэглэгээ: Коб/М VI, 83/1-18)
47	Хойд Цэнхэрийн гол-3	Манхан	МЗТСХЭ 1984	7	Дээд палеолит
48	Хойд Цэнхэрийн гол-4	Манхан	МЗТСХЭ 1984	15	Дунд палеолит
49	Булган-1	Булган	МЗТСХЭ 1984	28	Дээд палеолит (5 ш) Мезо-неолит (23 ш)
50	Булган-2	Булган	МЗТСХЭ 1984	4	Палеолит (2 ш) Неолит (2 ш)
51	Булган-3	Булган	МЗТСХЭ 1984	2	Дунд палеолит
52	Булган-4	Булган	МЗТСХЭ 1984	14	Дунд палеолит
53	Булган-5	Булган	МЗТСХЭ 1984	183	Неолит
54	Булган-6	Булган	МЗТСХЭ 1984	14	Неолит
55	Ярант	Булган	МЗТСХЭ 1984	33	Дээд палеолит
56	Үенч-1	Үенч	МЗТСХЭ 1984	426	Доод палеолит
57	Үенч-2	Үенч	МЗТСХЭ 1984	17	Дээд палеолит
58	Үенч-3	Үенч	МЗТСХЭ 1984	4	Дээд палеолит
59	Үенч-4	Үенч	МЗТСХЭ 1984	13	Доод палеолит
60	Үенч-5	Үенч	МЗТСХЭ 1984	6	Дээд палеолит

61	Үенч-6	Үенч	МЗТСХЭ 1984	12	Доод палеолит
62	Үенч-7	Үенч	МЗТСХЭ 1984	6	Дунд палеолит
63	Үенч-8 (Хөв)	Үенч	МЗТСХЭ 1984	107	Мезолит
64	Үенч-9 (Хөв)	Үенч	МЗТСХЭ 1984	111	Мезо-неолит
65	Үенч-10 (Бага хар толгой)	Үенч	МЗТСХЭ 1984	12	Мезо-неолит
66	Үенч-11	Үенч	МЗТСХЭ 1984	6	Мезо-неолит
67	Алтай-1	Алтай	МЗТСХЭ 1984	207	Дээд палеолит
68	Алтай-2	Алтай	МЗТСХЭ 1984	45	Дээд палеолит
69	Алтай-3	Алтай	МЗТСХЭ 1984	25	Палеолит (12 ш) Мезолит (13 ш)
70	Алтай-4	Алтай	МЗТСХЭ 1984	66	Дээд палеолит
71	Барлаг гол-1	Алтай	МЗТСХЭ 1984	147	Доод палеолит (7 ш) Дунд палеолит (108ш) Дээд палеолит (32 ш)
72	Барлаг гол-2	Алтай	МЗТСХЭ 1984	80	Дунд палеолит
73	Барлаг гол-3	Алтай	МЗТСХЭ 1984	422	Дунд палеолит (48 ш) Дээд палеолит (374 ш)
74	Барлаг гол-4	Алтай	МЗТСХЭ 1984	69	Дээд палеолит
75	Барлаг гол-5	Алтай	МЗТСХЭ 1984	3	Доод палеолит
76	Барлаг гол-6	Алтай	МЗТСХЭ 1984	12	Неолит
77	Мөст-3 (Уртын сайрын гол)	Мөст	МЗТСХЭ 1984	5	Доод палеолит
78	Мөст-4 (Уртын сайрын гол)	Мөст	МЗТСХЭ 1984	6	Дээд палеолит
79	Мөст-5 (Халзан хошуу)	Мөст	МЗТСХЭ 1984	5	Дээд палеолит
80	Мөст-6 (Халзан хошуу)	Мөст	МЗТСХЭ 1984	3	Дээд палеолит
81	Мөст-7 (Хүрэн толгой)	Мөст	МЗТСХЭ 1984	3	Дээд палеолит
82	Мөст-8 (Ямаатын уул)	Мөст	МЗТСХЭ 1984	5	Дээд палеолит
83	Хойд Цэнхэрийн гол (А)	Манхан	МФрХЭ	123	Дунд палеолит
84	Хөх өгөг	Манхан	МФрХЭ	73	Дунд палеолит



85	Хойд Цэнхэрийн гол (С)	Манхан	МФрХЭ	41	Дунд палеолит
86	Тахилтын хотгор	Манхан	МФрХЭ	100	Дээд палеолит
87	Зах Булаг	Манхан	МФрХЭ	317	Дээд палеолит
88	Цахирын үзүүр	Манхан	МФрХЭ	101	Дээд палеолит
89	Цахирын хөдөө	Манхан	МФрХЭ	4	Дээд палеолит
90	Төгрөг гол	Манхан	МОХЭ 2001	47	Дунд палеолит
91	Манхан 24А	Манхан	МОХЭ 2001	25	Дунд палеолит
92	Дунд Цэнхэрийн гол	Манхан	МОХЭ 2001	5	Дунд палеолит
93	Хар үзүүр	Манхан	МОХЭ 2001	49	Дээд палеолит
94	Хар толгой	Манхан	МОХЭ 2001	4	Дунд палеолит
95	Балган толгой	Манхан	МОХЭ 2001	10	Дунд палеолит
96	Хойд Цэнхэрийн агуй	Манхан	МОХЭ 2001	2	Дээд палеолит
97	Бугатын үзүүр-III	Жаргалант	Буянтын экспедици 2008	105	Дунд палеолит (20 ш) Дээд палеолит (67 ш) Неолит (18 ш)
98	Баруун салаа-1	Ховд	Буянтын экспедици 2013	5	Дээд палеолит
99	Баруун салаа-2	Ховд	Буянтын экспедици 2013	2	Дээд палеолит
100	Баруун салаа-3	Ховд	Буянтын экспедици 2013	3	Дээд палеолит
101	Хонгио гол	Эрдэнэбүрэн	Түүх, археологийн хүрээлэнгийн авран хамгаалах экспедици 2016	209	Дунд палеолит (206) Дээд палеолит (3)
102	Хавцалын гол	Эрдэнэбүрэн	Түүх, археологийн хүрээлэнгийн авран хамгаалах экспедици 2016	303	Дээд палеолит